

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/93/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН СУРГУУЛИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## 1. Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын ТАЙЛАН .....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.4 Зөвлөмж.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ТӨА-2022/93/-НА-СТА-ТШЗ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/113  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020371

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>82,329,352.91</b>	<b>87,083,559.95</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>82,329,352.91</b>	<b>87,083,559.95</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>78,200.00</b>	<b>328,300.00</b>
35130	Эм боох материал	78,200.00	328,300.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>76,911,152.91</b>	<b>81,805,259.95</b>
35410	Бичиг хэргийн материал	1,229,300.00	839,300.00
35420	Аж ахуйн материал	75,308,767.91	69,543,146.91
35430	Сэлбэг хэрэгсэл	140,000.00	140,000.00
35460	Хүнсний материал	233,085.00	1,147,860.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	10,134,953.04
35600	Мал амьтад	5,340,000.00	4,950,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,705,697,309.97</b>	<b>1,688,460,777.68</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,705,697,309.97</b>	<b>1,688,460,777.68</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,518,793,309.97</b>	<b>1,501,556,777.68</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,608,297,660.75	1,621,732,660.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163,007,583.79)	(226,749,362.23)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,782,326.80	126,876,228.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,541,087.03)	(95,346,311.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,910,827.69	98,497,485.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,838,668.86)	(55,741,547.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,991,776.00	25,891,776.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,963,820.89)	(11,041,629.19)
39217	Ном	16,161,879.30	17,437,476.70
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>186,904,000.00</b>	<b>186,904,000.00</b>
39301	Програм хангамж	925,000.00	925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(925,000.00)	(925,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,904,000.00	186,904,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,788,026,662.88</b>	<b>1,775,544,337.63</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,788,026,662.88</b>	<b>1,775,544,337.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,788,026,662.88</b>	<b>1,775,544,337.63</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,988,484.54	276,988,484.54
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(73,075,900.95)</b>	<b>(84,334,103.24)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(18,865,196.84)	(71,851,777.99)
51220	Тайлант үеийн үр дүн	(54,210,704.11)	(12,482,325.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,584,114,079.29	1,582,889,956.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,788,026,662.88</b>	<b>1,775,544,337.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,065,021,586.71</b>	<b>1,040,819,652.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,217,086.71</b>	<b>54,369,617.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>30,217,086.71</b>	<b>54,369,617.98</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	26,082,510.80	37,643,913.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,134,575.91	16,725,704.18
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,804,500.00</b>	<b>986,450,035.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>814,042,500.00</b>	<b>781,064,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	814,042,500.00	781,064,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,852,900.00</b>	<b>30,324,535.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,177,100.00	28,813,535.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,675,800.00	1,511,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>164,909,100.00</b>	<b>175,060,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,909,100.00	175,060,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,113,855,696.82</b>	<b>1,051,139,109.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,113,855,696.82</b>	<b>1,051,139,109.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>999,107,987.90</b>	<b>1,006,871,738.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>645,231,087.25</b>	<b>633,506,292.00</b>
210101	Үндсэн цалин	391,686,114.41	346,936,711.24
210102	Нэмэгдэл	176,338,043.84	225,716,708.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,841,119.00	19,369,204.96
210104	Урамшуулал	61,365,810.00	41,483,666.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80,881,603.84</b>	<b>84,956,012.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,398,714.61	59,613,312.85
210202	Тэтгэмжийн даатгал	5,868,168.71	6,335,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,686,659.79	5,068,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,175,469.19	1,267,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,752,591.54	12,672,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>163,906,095.00</b>	<b>173,201,625.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,229,082.00	9,178,909.00
210302	Түлш, халаалт	152,247,546.00	162,422,716.00
210303	Цэвэр, бохир ус	1,429,467.00	1,600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,840,482.00</b>	<b>8,437,825.00</b>
210401	Бичиг хэрэг	330,000.00	372,635.00
210402	Тээвэр, шатахуун	579,610.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	324,450.00
210404	Ном, хэвлэл	41,000.00	147,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	394,600.00

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,449,520.00	548,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	3,740,000.00
210408	Бараа материал акталсны зардал	3,625,352.00	2,410,740.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>13,804,100.15</b>	<b>18,290,825.14</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236,800.00	509,900.14
210502	Хоол, хүнс	11,346,680.15	16,143,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,220,620.00	1,637,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,002,600.00</b>	<b>5,263,750.00</b>
210604	Урсгал засвар	1,002,600.00	5,263,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>176,000.00</b>	<b>219,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	176,000.00	219,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>763,000.00</b>	<b>123,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	763,000.00	123,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,503,019.66</b>	<b>82,873,408.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,207,252.00	2,158,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,932,428.00	1,316,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,363,339.66	79,398,108.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,747,708.92</b>	<b>44,267,370.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,909,995.00</b>	<b>39,390,839.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,822,895.00	28,876,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,439,300.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,737,800.00	9,498,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	910,000.00	1,015,839.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>630,005.00</b>	<b>1,710,675.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,005.00	859,175.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	627,000.00	851,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>55,207,708.92</b>	<b>3,165,856.15</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,207,708.92	3,165,856.15
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(48,834,110.11)</b>	<b>(10,319,456.05)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,376,594.00</b>	<b>2,162,869.20</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	5,376,594.00	2,162,869.20
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(54,210,704.11)</b>	<b>(12,482,325.25)</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,988,484.54	1,585,373,778.85	(20,124,896.41)	1,842,237,366.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,259,699.57	1,259,699.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,988,484.54	1,585,373,778.85	(18,865,196.84)	1,843,497,066.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(1,259,699.56)	0.00	(1,259,699.56)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(54,210,704.11)	(54,210,704.11)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,988,484.54	1,584,114,079.29	(73,075,900.95)	1,788,026,662.88
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	276,988,484.54	1,584,114,079.29	(73,075,900.95)	1,788,026,662.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,224,122.96	1,224,122.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,988,484.54	1,584,114,079.29	(71,851,777.99)	1,789,250,785.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(1,224,122.96)	0.00	(1,224,122.96)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(12,482,325.25)	(12,482,325.25)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	276,988,484.54	1,582,889,956.33	(84,334,103.24)	1,775,544,337.63

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,034,804,500.00</b>	<b>986,450,035.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,804,500.00</b>	<b>986,450,035.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>814,042,500.00</b>	<b>781,064,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	814,042,500.00	781,064,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,852,900.00</b>	<b>30,324,535.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,177,100.00	28,813,535.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,675,800.00	1,511,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>164,909,100.00</b>	<b>175,060,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,909,100.00	175,060,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,031,292,650.00</b>	<b>972,798,035.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,031,292,650.00</b>	<b>972,798,035.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>916,645,336.08</b>	<b>930,819,064.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>645,231,087.25</b>	<b>633,506,292.00</b>
210101	Үндсэн цалин	391,686,114.41	346,936,711.24
210102	Нэмэгдэл	176,338,043.84	225,716,708.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,841,119.00	19,369,204.96
210104	Урамшуулал	61,365,810.00	41,483,666.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80,881,603.83</b>	<b>84,956,012.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,398,714.60	59,613,312.85
210202	Тэтгэмжийн даатгал	5,868,168.71	6,335,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,686,659.79	5,068,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,175,469.19	1,267,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,752,591.54	12,672,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>163,906,095.00</b>	<b>173,201,625.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,229,082.00	9,178,909.00
210302	Түлш, халаалт	152,247,546.00	162,422,716.00
210303	Цэвэр, бохир ус	1,429,467.00	1,600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,793,860.00</b>	<b>3,925,235.00</b>
210401	Бичиг хэрэг	330,000.00	447,235.00
210402	Тээвэр, шатахуун	579,610.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	500,000.00

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	36,350.00	183,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	388,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,032,900.00	1,906,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,915,190.00</b>	<b>22,846,900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,000.00	500,000.00
210502	Хоол, хүнс	11,335,190.00	19,346,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>176,000.00</b>	<b>219,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	176,000.00	219,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>708,000.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	708,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,033,500.00</b>	<b>11,164,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,943,600.00	7,884,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,089,900.00	3,280,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,647,313.92</b>	<b>41,978,970.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,809,600.00</b>	<b>37,102,439.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,722,500.00	27,029,350.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,439,300.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,737,800.00	9,156,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	910,000.00	916,289.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>630,005.00</b>	<b>1,710,675.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,005.00	859,175.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	627,000.00	851,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>55,207,708.92</b>	<b>3,165,856.15</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,207,708.92	3,165,856.15
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,511,850.00</b>	<b>13,652,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,511,850.00</b>	<b>13,652,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,511,850.00</b>	<b>13,652,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,511,850.00</b>	<b>13,652,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,511,850.00	13,652,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(3,511,850.00)</b>	<b>(13,652,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>956,125,500.00</b>	<b>952,100,468.85</b>	<b>4,025,031.15</b>	<b>99.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>956,125,500.00</b>	<b>952,100,468.85</b>	<b>4,025,031.15</b>	<b>99.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>926,313,800.00</b>	<b>924,154,829.85</b>	<b>2,158,970.15</b>	<b>99.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>633,525,700.00</b>	<b>633,506,292.00</b>	<b>19,408.00</b>	<b>100.00</b>
210101	Үндсэн цалин	423,842,200.00	346,936,711.24	<b>76,905,488.76</b>	<b>81.86</b>
210102	Нэмэгдэл	146,434,200.00	225,716,708.86	<b>(79,282,508.86)</b>	<b>154.14</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,196,000.00	19,369,204.96	<b>826,795.04</b>	<b>95.91</b>
210104	Урамшуулал	43,053,300.00	41,483,666.94	<b>1,569,633.06</b>	<b>96.35</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>85,527,600.00</b>	<b>84,956,012.85</b>	<b>571,587.15</b>	<b>99.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,184,900.00	59,613,312.85	<b>571,587.15</b>	<b>99.05</b>
210202	Тэтгэмжийн даатгал	6,335,300.00	6,335,300.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,068,200.00	5,068,200.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	1,267,100.00	1,267,100.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	12,672,100.00	12,672,100.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>174,060,800.00</b>	<b>173,201,625.00</b>	<b>859,175.00</b>	<b>99.51</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,438,100.00	9,178,909.00	<b>2,259,191.00</b>	<b>80.25</b>
210302	Түлш, халаалт	162,422,700.00	162,422,716.00	<b>(16.00)</b>	<b>100.00</b>
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	1,600,000.00	<b>(1,400,000.00)</b>	<b>800.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,845,000.00</b>	<b>3,845,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	350,000.00	215,000.00	<b>135,000.00</b>	<b>61.43</b>
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	500,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210404	Ном, хэвлэл	335,000.00	335,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	388,200.00	<b>(228,200.00)</b>	<b>242.63</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,906,800.00	<b>93,200.00</b>	<b>95.34</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,551,700.00</b>	<b>22,846,900.00</b>	<b>704,800.00</b>	<b>97.01</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	20,051,700.00	19,346,900.00	<b>704,800.00</b>	<b>96.49</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>223,000.00</b>	<b>219,000.00</b>	<b>4,000.00</b>	<b>98.21</b>
210702	Дотоод албан томилолт	223,000.00	219,000.00	<b>4,000.00</b>	<b>98.21</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,580,000.00</b>	<b>4,580,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,400,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,180,000.00	3,180,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,811,700.00</b>	<b>27,945,639.00</b>	<b>1,866,061.00</b>	<b>93.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,811,700.00</b>	<b>27,945,639.00</b>	<b>1,866,061.00</b>	<b>93.74</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,891,200.00	27,029,350.00	<b>1,861,850.00</b>	<b>93.56</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.00	916,289.00	<b>4,211.00</b>	<b>99.54</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>956,125,500.00</b>	<b>777,898,843.85</b>	<b>178,226,656.15</b>	<b>81.36</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>781,064,700.00</b>	<b>777,898,843.85</b>	<b>3,165,856.15</b>	<b>99.59</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	781,064,700.00	777,898,843.85	<b>3,165,856.15</b>	<b>99.59</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>175,060,800.00</b>	<b>0.00</b>	<b>175,060,800.00</b>	<b>0.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	175,060,800.00	0.00	<b>175,060,800.00</b>	<b>0.00</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>843.00</b>	<b>0.00</b>	<b>843.00</b>	<b>0.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	0.00	<b>1.00</b>	<b>0.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>51.00</b>	<b>0.00</b>	<b>51.00</b>	<b>0.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	0.00	<b>1.00</b>	<b>0.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	0.00	<b>34.00</b>	<b>0.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	16.00	0.00	<b>16.00</b>	<b>0.00</b>
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>740.00</b>	<b>0.00</b>	<b>740.00</b>	<b>0.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>740.00</b>	<b>0.00</b>	<b>740.00</b>	<b>0.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	740.00	0.00	<b>740.00</b>	<b>0.00</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>51.00</b>	<b>0.00</b>	<b>51.00</b>	<b>0.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	34.00	0.00	<b>34.00</b>	<b>0.00</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн йлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	0.00	<b>1.00</b>	<b>0.00</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	0.00	<b>16.00</b>	<b>0.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>30,324,535.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,324,535.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>20,316,235.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	232,235.00
210401	Бичиг хэрэг	232,235.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,084,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,984,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,008,300.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,156,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,156,800.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	851,500.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	851,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>30,324,535.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>30,324,535.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,813,535.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрэн	1,511,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдэж, 1,942.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага өгсөн байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 534,064.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,340.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,738.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 781,064.7 мянга, орон нутгийн төсвөөс 175,060.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 30,324.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 986,450.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 37,643.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 13,652.0 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 13,956.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, 15,033.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 928.4 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 13,375.7 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 64,890.7 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 4,402.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 81,264.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөггүй тайлагнагдсан.

#### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 87,083.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,688,460.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	82,329.3	87,083.5	4,754.2
Үндсэн хөрөнгө	1,705,697.3	1,688,460.8	(17,236.5)
Нийт хөрөнгө	<b>1,788,026.7</b>	<b>1,775,544.3</b>	<b>(12,482.4)</b>
Засгийн газрын хувь оролцоо	1,788,026.7	1,775,544.3	(12,482.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>1,788,026.7</b>	<b>1,775,544.3</b>	<b>(12,482.4)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 87,083.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 4,754.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,688,460.8 мянган төгрөг болж 17,236.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдэл байгуулснаас голлон шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,775,544.3 мянган төгрөг болж, 12,482.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 884,864.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 175,060.8 мянган төгрөг, үүнээс урсгал

зардалд 1,059,925.2 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 189,799.6 мянган төгрөгөөр бууруулан 870,125.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор 85,999.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 956,125.5 мянган төгрөгөөр баталжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 175,060.8 мянга, улсын төсвөөс 781,064.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 781,064.7 мянга, орон нутгийн төсвөөс 175,060.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 952,100.5 мянган төгрөгийг зарцуулж, 4,025.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 952,100.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас нийт 30,324.5 мянган төгрөг төвлөрч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 9,156.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 20,084.0 мянга, бичиг хэргийн зардалд 232.2 мянган төгрөг зарцуулж, 851.5 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 37,643.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 13,652.0 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 13,956.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого нэмэгдсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, алдаатай тайлагнасан, харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө ашиглагдаж байгаа, үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 139 мэдээллийг хугацаандаа, 5 мэдээллийг байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс 600.0 мянган төгрөгийн “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зайлшгүй шаардлагатай бус зардал гаргасан нь Төсвийн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 53,784,2 мянган төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа 1,510.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 56,496.1 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 55,896.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг залруулж, 6 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хандивын 51,019.6 мянган төгрөгийн орлогыг 120017, 120018 дансанд бус, бөөн дүнгээр 1200045 дансанд бүртгэснийг,
- Төвлөрүүлэх шилжүүлгийг 213303, 213305, 213403 дансанд бус, бөөн дүнгээр 213204 дансанд бүртгэснийг,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэг 4,025.0 мянган төгрөгөөр тохируулаагүйг,
- Нэмэлт төсвийн тайланд эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэг 851.5 мянган төгрөгөөр тохируулсныг тус тус залруулга хийлгэв.

#### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх.

##### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 168 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

## **2.2. Өгсөн зөвлөмж:**

ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

## **3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал.**

### **3.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Тооллогыг ажлыг чанартай явуулж, тооллогын баримтуудыг үйлдэх, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## **4. Өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал**

### **4.1. Илрүүлэлт:**

Харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **4.2. Өгсөн зөвлөмж:**

Харилцагчидтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## **5.Зардлын данстай холбоотой асуудал**

### **5.1.Илрүүлэлт:**

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг 600.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн

зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.2. Зөвлөмж:**

Төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**6. Шилэн данстай холбоотой асуудал**

**6.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**6.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, үнэ зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	10	56,496.1	4	55,896.1					6	600.0
	ДҮН	10	56,496.1	4	55,896.1					6	600.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)